

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН “ХОББИ” КЛУБУУДЫН ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 4,6.2-т Залуучуудыг хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгох, сөрөг зан үйл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, соён гэгээрүүлэх, залуучуудын чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулж, дугуйлан клубуудыг шинээр байгуулан дэмжихээр тусгасны дагуу Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар залуучуудын авьяас чадварыг хөгжүүлэх, мэдлэг мэдээллээр хангах, уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, санаачлагатай, бүтээлч, нийгмийн идэвхтэй, мэргэжилдээ эзэн болсон залуучуудыг нэгтгэх, нэмэгдүүлэх зорилгоор сайн дурын хобби клубуудыг нээн ажиллуулах гэж байна.

Мэргэжлийн клубуудын нэрс:

1. Сэтгүүлч мэргэжлийн клуб
2. Соёл урлагийн мэргэжлийн клуб
3. Олон улсын харилцаа мэргэжлийн клуб
4. Бизнесийн удирдлага мэргэжлийн клуб
5. Орчуулагч нарын клуб

Клубуудын нэрс:

1. Номын клуб
2. Гадаад хэл сонирхогчдын клуб
3. Кино урлаг сонирхогчдын клуб
4. Илтгэгч залуусын клуб
5. Уран зураг сонирхогчдын клуб
6. Хөгжлийн бэрхшээлтэй (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-т хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ) залуучуудын “Бид хамтдаа” клуб (Хүртээмжтэй орчин бүрдүүлсний дараа тэргэнцэртэй иргэдийг хамруулна.)
7. Шатрын клуб
8. Сэтгэл судлаачдын клуб
9. Сайн дурын клуб
10. Амьдралын ухаан судлалын клуб

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”.

Залуучуудын клуб нь сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд клубуудын нэр, үйл ажиллагааны чиглэлийг залуучууд өөрсдөө шийдвэрлэнэ.

Боловсруулсан:

НЗХГ-ын мэргэжилтэн

О.Санжинхандмаа

НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН “ХОББИ” КЛУБУУДЫН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

Клубуудын эрх, бүтэц бүрэлдэхүүн, бусад байгууллагатай харилцах харилцаа зэрэг бүхий л үйл ажиллагааг дүрмээр зохицуулна.

Хоёр. Клубийн зорилго

Монгол Улсын хөгжлийн тулгуур болох залуучуудын авьяас чадварыг хөгжүүлэх, мэдлэг мэдээллээр хангах, уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, санаачлагатай, бүтээлч, нийгмийн идэвхтэй, мэргэжилдээ эзэн болсон залуучуудыг нэгтгэх, нэмэгдүүлэх хүмүүс хоорондын харилцааг өргөжүүлэхэд оршино.

Гурав. Клубийн ажиллах зарчим

3.1 Клубуудын үйл ажиллагаа нь чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх мэдээлэл солилцох сонирхолтой нийт оюутан, залуус хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй байна.

3.2 Клубууд нь албан ёсны ахлагчтай байна.

3.3 Клубуудын үйл ажиллагааны тайлан мэдээг клубийн ахлагч сард нэг удаа Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газарт бичгээр гаргаж өгнө.

3.4 Тухайн клубийн ахлагч урьдчилсан төлөвлөгөө, цагийн хуваарийг гаргаж Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар бичгээр мэдэгдэж цаг тохирно.

3.5 Клубийн эд хогшлыг ариг гамтай ашиглана.

3.6 Клубийн гишүүд харилцан бие биенээ хүндэтгэн ажиллана.

3.7 Клубийн байранд аливаа шалтгаанаар согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах, үйл ажиллагааны чиглэлээс гадуурх ажил зохион байгуулахыг хориглоно.

3.8 Клубийн үйл ажиллагаанд бүх гишүүд тэгш эрхтэй байна

3.9 Клубийн үйл ажиллагаанд нэгдсэн залуучууд хувь хүний үзэл бодол, санал, шүүмжлэлийг хүндэтгэн харилцана.

3.10 Хувь хүний эрх, амгалан тайван байдалд халдахгүй

3.11 Клубууд нь гадаад дотоодын байгууллагатай хамтран үйл ажиллагаа явуулах тохиолдолд Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газарт бичгээр мэдэгдэнэ.

3.12 Клубуудын ахлагч нь тухайн клубийнхаа төлөвлөгөөнд туссан ажлыг гүйцэтгэхэд удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэгтэй.

3.13 Клубуудын гаргасан санал санаачлагыг Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар хэлэлцэн дэмжин ажиллана.

3.14 Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газарт бичгээр мэдэгдэж Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга клубуудын ахлагч нарын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.15 Тухайн клубуудын үйл ажиллагаанд ирсэн залуус Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байрны В корпусын дүрэм журмыг баримтална.

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын
даргын оны дугаар сарын -ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

№	Зарын нэр	Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Сэтгүүлч мэргэжлийн клуб	1	3,954,600	3,954,600
2	Номын клуб	1	4,644,326	4,644,326
3	Илтгэгч залуусын клуб	1	160,000	160,000
4	Хөгжлийн бэрхшээлтэй залуусын “Бид хамтдаа” клуб (Хүртээмжтэй орчин бүрдүүлсний дараа тэргэнцэртэй иргэдийг хамруулна.)	1	400,000	400,000
5	Шатрын клуб	1	89,900	89,900
6	Сайн дурын клуб	1	1,149,303	1,149,303
7	Хэвлэмэл хуудас хэвлүүлэх /Брошур/	15клуб*200ш =3.000	200	600,000
8	Клубуудын үйл ажиллагааны урсгал зардал	15*15 клуб	1 сард нийт 35,814	
Нийт дүн				10.997.229